



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/595

Арвайхээр


Цэцэрлэг шинээр байгуулах тухай

Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны 261 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Хужирт суманд шинээр баригдсан 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг 3 дугаар цэцэрлэгээр үүсгэн байгуулсугай.

2. Хужирт сумын 3 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний дотор хийж, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, тусгай зөвшөөрөл авахад шаардагдах материалыг хуулийн дагуу бүрдүүлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), Хужирт сумын Засаг дарга (Т.Баярмөнх)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101093